



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/156/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ш.Мөнхцэцэг

Утас: 70003775, 88883776

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.2 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ЗГ Засгийн газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
З/ТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.22 № 218

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
А.ГАНТУЛГА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

011020928

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,355,699.00</u>	<u>18,668,195.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	19,355,699.00	18,668,195.00
351	Түүхий эд материал	3,482,410.00	3,665,410.00
35110	Тусгай зориулалттай материал	3,482,410.00	3,665,410.00
354	Хангамжийн материал	15,873,289.00	15,002,785.00
35410	Бичиг хэргийн материал	275,000.00	370,000.00
35420	Аж ахуйн материал	12,782,085.00	14,032,785.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,216,204.00	-
35470	Бусад хангамжийн материал	600,000.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>103,994,688.88</u>	<u>80,408,440.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	103,994,688.88	80,408,440.10
392	Биет хөрөнгө	103,994,688.88	80,408,440.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,000,000.00	5,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,999,999.52)	(3,124,999.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,509,090.00	66,509,090.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,974,999.15)	(51,925,756.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,026,660.00	50,026,660.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,200,615.03)	(30,710,712.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,349,830.00	6,349,830.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,003,913.30)	(2,606,580.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,763,636.00	56,763,636.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,475,000.12)	(15,872,727.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,800,000.00	22,800,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(22,800,000.00)	(22,800,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>123,350,387.88</u>	<u>99,076,635.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>123,350,387.88</u>	<u>99,076,635.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	123,350,387.88	99,076,635.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65,759,520.00	65,759,520.00
51101	Өмч: - төрийн	65,759,520.00	65,759,520.00
512	Хуримтлагдсан үр дүн	57,550,203.88	33,276,451.10
51210	Өмнөх үеийн үр дүн	57,550,203.88	57,550,203.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	(24,273,752.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,664.00	40,664.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>123,350,387.88</u>	<u>99,076,635.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	613,164,306.00	1,393,924,650.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,533,636.00	1,098,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,533,636.00	1,098,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,633,636.00	550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	770,000.00	550,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,863,636.00	-
120009	Бусад орлого	900,000.00	548,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	588,630,670.00	1,392,826,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,370,870.00	7,749,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,370,870.00	4,749,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,259,800.00	1,385,077,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,259,800.00	1,385,077,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	651,485,494.92	1,418,198,402.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,485,494.92	1,418,198,402.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,673,921.93	1,183,921,764.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,360,688.01	325,507,616.00
210101	Үндсэн цалин	302,958,811.52	243,564,115.00
210102	Нэмэгдэл	22,101,376.49	71,835,501.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,300,500.00	10,108,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,971,915.00	44,088,875.76
210201	Тэтгэврийн даатгал	29,555,793.00	30,845,122.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,265,338.00	3,433,376.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,871,867.00	2,731,094.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,570,843.00	542,340.94
210205	Эрүүл мэндийн даатгал	6,708,074.00	6,536,941.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,801,851.00	1,973,578.00
210302	Түлш, халаалт	2,801,851.00	1,973,578.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,100,092.12	8,036,000.00
210401	Бичиг хэрэг	1,356,700.00	875,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,484,000.00	6,339,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,477.00	820,950.00
210408	Бараа материал акалсны зардал	57,349,915.12	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,739,296.00	3,642,368.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	69,600.00
210602	Тавилга	30,000.00	-
210604	Урсгал засвар	7,709,296.00	3,572,768.00

2107	Томилолт, зочны зардал	2,390,200.00	2,803,400.00
210702	Дотоод албан томилолт	2,390,200.00	2,803,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,000.00	990,236.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	208,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	115,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	41,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,619,879.80	796,879,690.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,312,781.00	773,293,442.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,307,098.80	23,586,248.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,811,572.99	234,276,638.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,907,200.00	22,048,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,548,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,907,200.00	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,904,372.99	212,228,538.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,904,372.99	212,228,538.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(38,321,188.92)	(24,273,752.78)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	539,895.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	539,895.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(539,895.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(38,861,083.92)	(24,273,752.78)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	65,759,520.00	40,664.00	57,550,203.88	123,350,387.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,759,520.00	40,664.00	57,550,203.88	123,350,387.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,759,520.00	40,664.00	57,550,203.88	123,350,387.88
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,273,752.78	-24,273,752.78
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,759,520.00	40,664.00	33,276,451.10	99,076,635.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	590,300,670.00	1,393,924,650.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,670,000.00	1,098,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,670,000.00	1,098,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	770,000.00	550,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	770,000.00	550,000.00
120009	Бусад орлого	900,000.00	548,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	588,630,670.00	1,392,826,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,370,870.00	7,749,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,370,870.00	4,749,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,259,800.00	1,385,077,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,259,800.00	1,385,077,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	590,300,670.00	1,393,924,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,300,670.00	1,393,924,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,489,097.01	1,159,648,011.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,360,688.01	325,507,616.00
210101	Үндсэн цалин	295,800,635.52	243,536,551.00
210102	Нэмэгдэл	29,259,552.49	71,863,065.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,300,500.00	10,108,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,971,915.00	44,088,875.76
210201	Тэтгэврийн даатгал	29,555,793.00	30,845,122.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,354,035.00	3,367,076.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,783,170.00	2,619,740.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,482,147.00	653,694.88
210205	Эрүүл мэндийн даатгал	6,796,770.00	6,603,241.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,801,851.00	2,273,578.00
210302	Түлш, халаалт	2,801,851.00	2,273,578.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,791,177.00	8,131,400.00
210401	Бичиг хэрэг	1,397,700.00	966,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,484,000.00	6,343,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,477.00	820,950.00
2105	Нормативт зардал	5,449,985.00	1,250,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,449,985.00	1,250,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,425,500.00	1,071,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,083,500.00	69,600.00
210602	Тавилга	2,500,000.00	-
210604	Урсгал засвар	9,842,000.00	1,002,000.00

2107	Томилолт, зочны зардал	2,390,200.00	2,803,400.00
210702	Дотоод албан томилолт	2,390,200.00	2,803,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,000.00	1,344,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	208,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	470,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	41,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,607,781.00	773,176,042.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,607,781.00	773,176,042.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,811,572.99	234,276,638.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,907,200.00	22,048,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,548,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,907,200.00	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,904,372.99	212,228,538.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,904,372.99	212,228,538.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,414,037,100.00	1,174,946,561.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,037,100.00	1,174,946,561.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,391,989,000.00	1,152,898,461.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,282,900.00	325,507,616.00
210101	Үндсэн цалин	299,090,900.00	243,536,551.00
210102	Нэмэгдэл	35,232,000.00	71,863,065.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,960,000.00	10,108,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,639,300.00	44,088,875.76
210201	Тэтгэврийн даатгал	32,747,400.00	30,845,122.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,473,000.00	3,367,076.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,778,600.00	2,619,740.96
210204	Ажилгүйдлийн даатгал	694,300.00	653,694.88
210205	Эрүүл мэндийн даатгал	6,946,000.00	6,603,241.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,176,600.00	2,273,578.00
210301	Гэрэл, цахилгаан	902,800.00	-
210302	Түлш, халаалт	2,273,800.00	2,273,578.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,131,400.00	8,131,400.00
210401	Бичиг хэрэг	1,044,600.00	966,750.00
210402	Тээвэр, шатахуун	6,343,700.00	6,343,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	743,100.00	820,950.00
2105	Нормативт зардал	1,250,700.00	1,250,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,250,700.00	1,250,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,071,600.00	1,071,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,600.00	69,600.00
210604	Урсгал засвар	1,002,000.00	1,002,000.00
2107	Томилот, зочны зардал	3,646,800.00	2,803,400.00
210702	Дотоод албан томилот	3,646,800.00	2,803,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,345,000.00	1,344,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	208,300.00	208,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,000.00	470,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,700.00	41,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	375,000.00	375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	979,444,700.00	766,426,492.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	979,444,700.00	766,426,492.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,048,100.00	22,048,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,048,100.00	22,048,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,548,100.00	19,548,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,414,037,100.00	1,174,946,561.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,048,100.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	22,048,100.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,391,989,000.00	1,173,848,561.76
132001	Орон нутгийн төсвөөс	1,391,989,000.00	1,173,848,561.76
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,098,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	550,000.00
120009	Бусад орлого	-	548,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,749,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,749,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,749,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,749,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,749,550.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,749,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,749,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,749,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилт болон үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Ш.Мөнхцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 76 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь 2021 онд орчны бохирдлыг бууруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 452,029.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,520.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,164.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 18,668.2 мянган төгрөг болж 687.5 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,449.2 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 780,760.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан төсвийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 766,713.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,414,037.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,414,037.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,414,037.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,391,989.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,048.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,385,077.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,098.0 мянган төгрөг, нийт 1,386,175.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,174,946.6 мянган төгрөг буюу 84.8 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 211,228.5 мянган төгрөг буюу 15.2 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дорнод аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 4,749.6 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанд бий болгосон нэмэлт орлого 2,000.0 мянган төгрөг, нийт 7,749.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 6,749.6 төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зарцуулж, 1,000.0 мянган төгрөгийн татан төвлөрүүлэх хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,448,262.6 мянган төгрөгийн 25 орлогын мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй байгаа тул Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх..

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 153,800.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 2 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 161,370.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17,215.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 144,154.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

1. Тайлант онд 2 ААН-ээс 7,194.9 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Хувь хүнд олгосон ажил үйлчилгээний хөлс 10,020.4 мянган төгрөгөөс ХХОАТ суутгаагүй, суутгагчаас хувь хүнд олгохдоо татвар суутгаагүйг ТТ12 тайланд мэдээлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д Үндсэн ажлын

газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант жилийн эцсийн үлдэгдэлд тайлагнасан авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тайланг үнэн зөв бэлтгэх, ХХОАТ-ын хуулийн дагуу тайлагнах, суутгагчаас хувь хүнд олгосон хөлсийг цахим төлбөрийн бүртгэлд бүртгүүлэх, Албан шаардлага өгөх.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд :

1. Зардлын хэмнэлттэй холбоотой асуудал

1.1 *Илрүүлэлт* : МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 " үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах " зүйл заалтын хэрэгжилтийг хангаж удирдлагаас тушаал шийдвэр гаргаж ажиллаагүй.

1.2 *Өгсөн зөвлөмж*: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана ” гэж заасны дагуу төсвийн хэмнэлтийг гаргах тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 *Илрүүлэлт* : Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно “, үндсэн хөрөнгийн бүртгэлийн анхан шатны баримтад “ ажилчин албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл “ – ээс үзэхэд үндсэн хөрөнгийг эд хариуцагч нарт хүлээлгэн өгсөн анхан шатны баримт гарын үсэггүй, эд хариуцагчийн гэрээ гарын үсэг зурагдаагүй.

2.2 *Өгсөн зөвлөмж* : Анхан шатны баримтын иж бүрдлийг хангах, үндсэн хөрөнгийг ажилчин албан хаагчдад ашиглуулахдаа эд хариуцагч тус бүрээр гарын үсэгтэй хүлээлцэх, эд хариуцагчийн гэрээг гарын үсэгтэй байгуулах.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	5	161.3	-	-	-	-	3	17.2	2	144.1